

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨӨНД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020-2024 ОНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Зорилго	УХЖТ-ний төсөл, арга хэмжээ	ЗГҮАХ-ийн арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилт	УИХТГ-ын үнэлгээ
1. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1		1.1.3. Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах	1.1.3.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна.	Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах	Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулсан байна.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлсэн. Улмаар төслийн Удирдах хорооны хурлаар дэмжигдэж, АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2023 онд нийлүүлэхээр шийдвэрлэсэн. Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт ЗӨСТ байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийг 2023 оны төсвийн төсөлд тусгасан боловч 2023 онд шинээр барилга байгууламж барихгүй байх шийдвэртэй холбоотойгоор хойшлогдсон. Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Төв аймагт 33 орон тоо бүхий "Зоонозын өвчин судлалын төв" болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий "Тандалтын нэгж"-ийг 2024 онд байгуулах, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн "Зоонозын өвчин судлалын төв"-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/2957 тоот албан бичгээр тандалтын нэгжийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах асуудлыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргатай зөвшилцөх, Зоонозын өвчин судлалын төвийг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын санал, дүгнэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн үндэслэлээр тогтоолын төслийг буцаасан.	30
2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
2	2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	2.1.1. Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх	2.1.3.2. Зүрх судасны төв байгуулна.	Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа "Зүрх судасны төв байгуулах" төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжаар Испани Улсын "Идом" ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан. Барилгын төсвийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй, төсөвгүй гэх шалтгаанаар барилгын гүйцэтгэл гацсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Зүрх судасны төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
3		2.1.2. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх	2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн /хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад/ тооцооллыг хийсэн байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2х30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл, арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
4		2.1.3. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх	2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.	Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, "Хар чонот" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээний төсөл боловсруулах үед "Хар чонот" ХХК нь Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Төндөрт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай" 213 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж, төндөрийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр дахин зарласан. Дахин зарласан төндөрийг "Захирааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай" Нийслэл дэх Захирааны хэргийн анхан шатны Шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 128/ШЗ2022/7229 захирамжаар захирааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна. Барилгын ажлын төсөвт өртөг 18.5 тэрбум төгрөг бөгөөд 2022 оны улсын төсөвт 2.0 тэрбум төгрөгөөр суусан боловч ажил эхлээгүй. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй тул барилгын ажил эхлээгүй.	0

5	2.1.6. Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх	2.1.3.8.Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина.	Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх	Зураг, төсөв хийгдэж, барилгын ажил эхэлсэн байна.	Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн зураг, төсвийн зардалд Барилга, хот байгуулалтын сайдын багцад 268.9 сая төгрөгийн эх үүсвэр тусгагдсан бөгөөд зураг төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, "Татах хүч" ХХК-тай гэрээ байгуулан зураг төсвийг хийгэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м2 газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
6	2.1.15. Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх	2.1.8.4.Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ.	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх	21 аймгийн нэгдсэн эмнэлэг сүлжээнд холбогдож, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна.	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, нянгийн тэсвэржилтийн WHO.NET программ дээр ажиллаж сургах сургалтад 21 аймгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулах хөтөлбөр, төлөвлөгөөг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нян судлалын лабораторитой хамтран боловсруулж байна. ДЭМБ-ын Номхон далайн Баруун бүсийн Нянгийн тэсвэржилтийн тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн манай улсад 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 14-ний өдрүүдэд ажиллан "Нянгийн тэсвэржилтийн тандалт, тэсвэржсэн нянгийн мэдээллийг боловсруулах нь" сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 40 хүн хамрагдсанаас цахимаар 21 аймгийн лабораторийн 25 хүн оролцсон. WHONET-ийн тухай ойлголт, хэрэглээ, дүгнэлт гаргах арга-члал, шинэчлэлийн талаар олон улсын зөвлөх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, манай улсад WHONET програмыг хэрхэн ашиглаж байгаа болон Монгол Улс тэсвэржсэн нянгийн мэдээллийг ДЭМБ-ын "GLASS" системд хүргүүлдэг болох талаар мэдээллийг түгээсэн байна.	30
7	2.1.21. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирусстэй иргэдийг эмчилгээнд хамруулах	2.1.1.5."Элэг бүтэн Монгол" арга хэмжээ хэрэгжүүлнэ.	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирусстэй иргэдийг эмчилгээнд хамруулах	Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/577 дугаар тушаалаар "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Элэгний D вирусийн эсрэг Bulevir tide (Hepcludex) эмийг Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулсан. Гэвч D вирусийн эмийг манай улсад импортлон оруулж ирэхгүй байгаа тул иргэдийг эмийн эмчилгээнд хамруулах ажил удааширсан. Шалтгаан нь Bulevir tide эм нь анх лиценз эзэмшигч MYR GmbH компанийн нэр дээр Европын эмийн агентлагт нөхцөлт зөвшөөрөл авсан бөгөөд эзэмшигчийн лиценз нь АНУ-ын Гилеад Сайенс компанид 2020 оны 12 дугаар сард шилжиж, улмаар АНУ-ын Хүнс эмийн агентлагт (FDA) Bulevir tide эмийг бүртгүүлэхээр хүлээгдэж байна. Эмийн эмчилгээний талаар Гилеад Сайенс компаниас 2022 оны 06 дугаар сарын 04-ны өдөр монголын эмч нарт сургалтыг зохион байгуулсан.	0
8	2.1.25. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх	2.1.3.6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх	Цогцолбор салбар II-ын барилга баригдаж эхэлсэн байна.	Халдварт өвчин судлалын төвийн цогцолбор салбар байгуулах зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
9	2.1.27. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах	2.1.7.1.Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулна	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8 хувиар байгуулсан байна.	ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна. Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляци, валютын ханшийн өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төлвөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн "Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай" 13 дугаар тогтоолоор гаргажээ.	30
10	2.1.28. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах	2.1.3.7.Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна	Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах	Зураг, төсөв хийгдэж, барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад зураг төсөв боловсруулах төсвийг тусгасан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын байгуулсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төсвийн ажил 80.0 хувьтай үргэлжилж байна. Газрын асуудал шийдэгдэж, Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт барилга барихаар болсон. Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
11	2.1.29. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох	2.1.14.1.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох	3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.	Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээний асуумжийг ЭМЯ, НЭМУТ, МХЕГ хамтран 2022 онд боловсруулж, судалгаа авсан. Ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах систем, ус хангамж, гарын эрүүл ахуй, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн байдал зэрэг чиглэлээр асуумжийг 21 аймгийн нийт 358 сумын Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн улсын хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээллийг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан сумын ЭМТ-ийн 76.5 хувь нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1 хувь нь хааяа ашигладаг, 2.0 хувь огт ашигладаггүй бол 8.4 хувь нь гадна нүхэн жорлонгүй байна. Нүхэн жорлон ашигладаг байдлыг бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2 хувь, зүүн бүс 78.6 хувь, хангайн бүс 78.1 хувь, төвийн бүс 60 хувьд нүхэн жорлон тогтмол ашигладаг байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй санхүүжих дүн 1.8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжийн зураг төсөл хийгдэж байна.	30

12		2.1.32. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих	2.1.11.2. Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина.	Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих	Барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 40 хувьд хүргэсэн байна.	Энэхүү арга хэмжээг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" төслийн хүрээнд хэрэгжүүлж байна. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд I үе шатын хүрээнд "Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл"-ийн зургийн зөвлөх компани "Татах хүч" ХХК шалгарч 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын явц 40 хувьтай байна. Түүнчлэн 2022 онд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийхээр "Татах хүч" ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын эскиз зургийг дуусган, ЭМЯ-ны ТАХ-аар 10 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, аймгийн ерөнхий архитектораар батлуулахаар хүргүүлсэн. Барилга архитектурын зургийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор эцэслэн, ОБЕГ, МХЕГ, БХТ-д хүргүүлэн магадлалд оруулахаар ажиллаж байна.	0
13	2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	2.2.3.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл"-ийн барилгын ажлыг эхлүүлэх, солилцох захидлын төслийг боловсруулж, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнүүдийг холбогдох байгууллагуудаар хийлгэж, БНХАУ-ын талд хүргүүлээд байна.	0
14		2.4.4. Шинжлэх ухаан, инновацын салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх	2.4.3.4.Шинжлэх ухаан, технологи, инновацийн статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.	Шинжлэх ухаан, инновацын салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх	Эрдэм шинжилгээний байгууллагын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах бодит хувь нэмрийг өсгөж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлсэн байна. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.54 хувьд хүргэсэн байна.	2022 оны төсвийн тодотголоор эрдэм шинжилгээний зардлыг төсвийн хэмнэлттэй холбоотойгоор 5,0 тэрбум, шинжлэх ухаан, салбарын хөрөнгө оруулалтыг 18,0 тэрбумаар танасан нь судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар үр дүнд, салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл болон эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 0.54 хувьд хүргэх зорилтот түвшинд хүрэх боломжийг хязгаарласан. Хэдийгээр хязгаарлалтад орсон ч салбарын зүгээс 2022 онд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн 6 зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлээд байна. Үүнд: Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг тогтоож, "Шинжлэх ухаан технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", "Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнгээр эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг үр дүнд суурилан санхүүжүүлсэн нь шинжлэх ухаан технологи, инновацын тэргүүлэх чиглэлд судалгааны төсөл зарлан, сонгон шалгаруулах зарчмаар өрсөлдөөнт санхүүжилт бүхий судалгааны дэмжлэг авах нөхцөл бүрдсэн. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.11 хувь /Төсвийн хэмнэлт, салбараас үл хамаарах шалтгаанаар/ 2023 оны төсвийн хязгаарт зорилтот түвшинд хүргэх тооцоололд үндэслэн эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг одоогийн байгаа түвшнээс хамгийн багадаа 4 дахин нэмэгдүүлэхээр санал өгсөн ч улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан судалгаа хөгжүүлэлтэд зарцуулах төсвийн зардал 13,0 тэрбум төгрөгөөр батлагдсан.	30
15	2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	2.5.1. Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	2.5.1.1.Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна.	Тэтгэврийн шинэчлэл хийх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс "Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ" гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн. Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсан хуралдаанаар хуулийн төслүүдийг дахин буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан үзэл баримтлалд нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд Монгол Улс олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой байхаар, одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулав.	30

16	2.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах	2.5.8.9.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.	Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард боловсруулан баталгаажуулсан ба барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар сард зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулагдсан. Барилга угсралтын ажил 24% хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2022 онд 3,0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.	30
17	2.5.12. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх	2.5.6.4.Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг нэвтрүүлж, цахимжуулна.	Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх	Ядуурлын түвшин буурч, өрхийн орлого нэмэгдсэн байна.	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилт, үйл ажиллагааны хүрээнд хүн амын бүлгүүдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, санхүүгийн дэмжлэг болон зээлд хамруулах, борлуулалтын дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг дэмжих зэрэг арга хэмжээг "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр" "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-үүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор батлан 2022-2023 онд хэрэгжүүлж байна. ҮСХ-ны 2020 оны статистик мэдээгээр МУ-ын ядуурлын түвшин 27.8 хувь байна. 2022 оны 3 дугаар улирлын мэдээгээр МУ-д хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.0 хувь байна. Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны 12 сарын байдлаар 627472 залуучууд буюу нийт залуучуудын 62 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлэгч залуучуудын 30 хувь нь ажилд холбон зуучлах үйлчилгээнд хамрагддаг бөгөөд тэдгээрийн 57 хувь нь байнгын түр ажлын байранд, 43 хувь нь цагийн ажлын байранд тус тус зуучлагдаж байна.	30
18	2.5.14. Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах	2.5.7.2.Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зорилгоор өрхийн амьжиргааны түвшинг төрийн байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлодог байхаар аргачлалыг шинэчлэн, нэвтрүүлнэ.	Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах	Өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох шинэчлэн баталсан аргачлалд үндэслэн 2022 онд өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг нийт өрхийн 30 хувийг хамруулан зохион байгуулна.	Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл болон холбогдох төрийн мэдээллийн санг ашиглаж, уялдуулан загварын үнэлгээ, тооцооллыг олон хувилбараар үнэлж, гүйцэтгэлийг сайжруулж буй хувилбаруудыг нэгтгэн, шинэ загварыг боловсруулан загварын үнэн бодит байдлыг шалгаж, эцсийн загварын төслийг боловсруулсан. Боловсруулсан хосолмол загварыг туршиж туршилтын судалгааг ТББ-тай хамтран УБ хотын 6 дүүрэг, Орхон, Булган, Хэнтий, Дундговь аймгуудын 400 өрхийг хамруулсан. Туршилтын судалгааны үр дүнд үндэслэн судалгааны үзэл баримтлал, аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ҮСХ-ны дарга, ХНХ-ын сайдын 2022 оны А/84, А/89 хамтарсан тушаалаар "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал" батлагдсан. Аргачлал батлагдсантай холбогдуулан дараах ажлуудыг хийсэн. Үүнд: - Өрхийн нэгдсэн мэдээллийн сангийн системийг шинэчлэх дотоодын 3 мэдээллийн технологийн зөвлөхийн хийх ажлын даалгаварт санал өгч, зөвлөхүүдтэй хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө, мэдээллийн сангийн системийн зохиомж, асуулгын өгөгдөл оруулах үеийн өгөгдлийн алдаа шалгах дүрмүүд, Захиргааны мэдээлэл хадгалагдах хүснэгтийн загвар, аргачлалын ашиглагдах тооцооллын бодлогын даалгаврын дагуу код бичиж, боловсруулсан. Мөн яамны саналын дагуу андройд болон IOS 2 үйлдлийн системд зориулсан судалгааны аппликейшнийг таблет болон гар утсанд зориулж хийсэн. - Аргачлалд тусгагдсан төрийн байгууллагуудаас мэдээлэл сервисээр солилцох гэрээ болон хөгжүүлэлтийг хийсэн. - Судалгааг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн тооцооллыг ХХҮЕГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан.	30

19	2.6.2. Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах	2.6.1.3. Үндэсний номын сангийн шинэ барилга	Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах	Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна.	Үндэсний номын сангийн барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр "Акми холдинг" ХХК-тай анх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /хуучнаар/-аас 2014.08.21-нд 11,999.8 сая төгрөгөөр гэрээ байгуулж, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар барилгын нийт төсөвт өртөг 19,900.0 сая төгрөг болж, тухайн онд санхүүжих дүн 2,081.8 сая төгрөгөөр батлагдсан. 2022.12.07-ны өдөр барилгын зураг төслийн зохиогч "Эгэл зураг төсөл" ХХК-ийн захирал Д.Оюунчимэг, Архитектор С.Сэргэлэн нартай Соёлын дэд сайд, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нар уулзаж, барилгын үлдэгдэл ажлын төсвийг хийх талаар ярилцсан. 2022.12.09-ний байдлаар Ажлын хэсгийн гишүүд Үндэсний номын сангийн барилгын ажлын гүйцэтгэсэн болон үлдэгдэл ажлын тоо хэмжээг гаргасан. 2022.12.13-нд Соёлын яам дээр Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер, "Акми холдинг" ХХК-ийн захирал Ганбилэг, ерөнхий инженер Дамдиндорж, Соёлын яамны хяналтын инженерийн бүрэлдэхүүнтэй баталгаажуулах хурлыг хийж, барилга дээр очиж тоо хэмжээг тулгаж хянасан. Үүний үр дүнд гүйцэтгэлээр гаргасан тоо хэмжээ барилга дээр хийсэн ажлын тоо хэмжээ зөрсөн, давхацсан асуудал илэрсэн тул чиглэл тус бүрийн хяналтын инженерүүд /цахилгаан, сантехник, барилга/ тухайн үед гаргасан гүйцэтгэл 1-19 хүртэлх холбогдох материалтай нэг бүрчлэн танилцан, тоо хэмжээг нарийвчлан тулгаж ажил хийгдэж байна. 2022.12.20-ны өдөр "Акми холдинг" ХХК-тай байгуулсан 2014 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 3/206 дугаартай Үндэсний төв номын сангийн барилга угсралт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажил гүйцэтгэх гэрээг цуцлахтай холбоотой ажиллагаа болон тус ажиллагаатай холбогдон гарсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, хууль зүйн туслалцаа авах зорилгоор Өмгөөллийн "Жэй Эн Ти партнерс" ХХН-тэй 2022/27 дугаар гэрээ байгуулсан.	0
20	2.6.3. Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх	2.6.2.7. Соёлын өвийг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ.	Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх	Мэдээллийн санд оруулахаар төлөвлөсөн соёлын өвийн мэдээллийн 10 хувийг бүрдүүлсэн байна.	Соёлын салбарын мэдээллийн технологийн дунд хугацааны бодлогын баримт бичиг "Цахим соёл" арга хэмжээний төслийг боловсруулан Соёлын сайдын 2022 оны А/91 тоот тушаалаар батлуулсан. Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим сан, Улсын санд худалдан авах хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийн цахим сан, Тусгай зөвшөөрөл лавлагааны систем, Музейн цахим хөтөч, тайлбарлагчийн систем, Соёлын үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, GLAM системийн ажлын даалгавар болон урын сан, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн сангийн ажлын даалгавруудыг ТНБД-аар, энэхүү ажлуудын хүрээнд зарцуулах зардлын тушаалыг соёлын сайдын 2022 оны 8 сарын 30-ны өдрийн А/304 тоот тушаалаар батлуулан ТНБД-ын 2022 оны 9 сарын 01-ний өдрийн А/61 тоот тушаалаар үнэлгээний хороог байгуулан гүйцэтгэгч сонгон шалгаруулалт зарлан баталгаажуулж гэрээ байгуулагдсан. Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд RICH 3.0 программ хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан. Уг Rich программд бүртгэсэн өвийн бүртгэлийг шууд шинэ системд хөрвүүлэх боломжтойгоор программчлахаар ажлын даалгаварт тусгасан тул одоо ашиглагдаж байгаа программд өвийн бүртгэлийг бүртгэх ажил амжилттай хийгдсэн.	0
3.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
21	3.1.4. "Алтанбулаг" чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох	3.1.17.3."Алтанбулаг" чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно	"Алтанбулаг" чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох	Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбогдсон байна.	"Алтанбулаг" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас төсөлд шаардагдах төсвийг бусад шаардлагатай дэд бүтцийн төслүүдэд шаардагдах хөрөнгө оруулалтын саналын хамт Монгол Улсын 2023 оны төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөвт тусгаадаагүй. Гаалийн ерөнхий газарт гаалийн бүртгэлийн системд цогц шийдлийг олж нэвтрүүлэх, бүсийн зорчигч, тээврийн нэвтрэлтийг хурдасгахад холбогдох арга хэмжээ авах тухай албан бичгийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1697 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30
22	3.1.5. Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах	3.1.4. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна. Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна."	Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах	Банкны салбарын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж зээлийн хүүг жилийн 13.8 хувьд хүргэсэн байна.	Зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаартай тогтоолоор батлан, Монгол улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж, стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Тус стратегийн баримт бичиг нь 4 заалт, 4 дэд заалтын хүрээнд тодорхойлсон 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд дараах үндсэн 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх; зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах зэрэг байна. Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих ажлын хүрээнд бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалсан. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн дундаж хүү 2019 оны 2 сард 16.9 хувь байсан бол 2020 оны төгсгөлд 14.8 хувьд хүрч, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 15.3 хувьтай байна. Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам гаргадаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сард гаргахаар хүлээгдэж байна.	30
23	3.1.8. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах	3.1.13.2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах	Холбогдох судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулсан байна.	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарын бүрэлдэхүүнтэй хуулийн баг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулаад байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг иргэд, олон нийт болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудын хууль, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн, судлаач багш нарын хүрээнд, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ (MORA) түүний гишүүдийн хүрээнд тус тус онлайн аар хэлэлцүүлсэн бөгөөд нийт 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	30

24	3.2.7. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	3.2.4.2.Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна.	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 30-нд байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн.	30
25	3.2.13. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	3.2.1.5.Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.	Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7 хувьтай хэвээр байна.	30
26	3.2.14. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	3.2.7.4."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай- металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулахүйлдвэрийг барина. 3.2.7.5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Иссэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна 3.2.7.7.Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна. 3.2.7.8.Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Салбар лаборатори байгуулна./	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг гүйцэтгэнэ /100 хувь/.	Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох төндөр шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 3 дахь удаагийн төндөр хүчингүй болсон, 4 дэх төндөр зарлахаар ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн төндөрийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. - Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын төндөр хүчингүй болсон. Дахин төндөр зарлахаар ажиллаж байна. -Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, ажлын төсөвт өртгийг батлуулах ажил хийгдэж байна. "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна.	30

27	3.2.15. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	3.2.7.4."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай- металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	"Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 10 хувьд хүргэсэн байна.	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанигай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. Тус ТЭЗҮ-г үндэслэн Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгарыг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын "Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж" боловсруулсан. Үүний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж төндөр зарлахаар ажиллаж байна.Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна. Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжаң Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xilxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн. Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахаас тээвэрлэхэд бэлэн болоод байна. Гэвч БНХАУ-д үүсээд буй Ковид-19 цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байгаа тул туршилтын ажлын гүйцэтгэлийн хугацааг 2023.11.10-ны өдөр дуусгах төлөвлөгөөг гүйцэтгэгчээс ирүүлсэн.	30
28	3.2.16. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих	3.2.7.5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	"Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэсэн байна /100 хувь/.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан "Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Гэвч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар тус ТЭЗҮ-ийг хэлэлцэж, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй 2022.12.14-ний өдөр цахим хурлыг зохион байгуулж ТЭЗҮ-ийг шинэчлэн засварлахаар тохиролцсон байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30 хувьтай байна.	30
29	3.2.21. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах	3.2.7.3.Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.	Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах	Гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийн татан авалт 88 хувьтай байна.	Дорноговь аймагт "МДМ" ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил цар тахал, хилийн хорио, үлдэгдэл хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн нэмэлт хөрөнгө оруулалтын хувилбаруудыг судалж байна.	0
30	3.3.14. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	3.3.3.2.Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ	Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	90.0 мянган тн мах экспортлосон байна.	1. ХХААХҮС-ын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/294 дүгээр тушаалаар байгуулагдсан Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг судалж, экспортыг нэг цөнхны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг цахимжуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2.ГХАН, БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай хамтран 2022.10.27-ны өдөр зохион байгуулсан "GIZ-CIQA Хүйтэн хэлхээний менежмент ба Хятад Улсын мах, махан бүтээгдэхүүний импорт" сэдэвт сургалт, уулзалтад экспортлогч 19 аж ахуйн нэгжийг хамруулсан. Тус уулзалтаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход мөрдөгдөж буй дүрэм журам, тавигдах шаардлагын талаар танилцуулж, санал солилцсон. 3. "Стратегийн хүнсний экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу Монгол Улсын 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд экспортлох, импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Зөвлөмж гаргуулсан. 4.ХХААХҮС-ын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 тоот тушаалын хүрээнд БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн экспортыг сэргээх ажлыг эрчимжүүлж, ажлын эсгийг төлөвлөгөөг батлан ажиллаж, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах талаар тавьсан шаардлагыг бүрэн хангаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай "нэмэлт гэрчилгээ"-ний загварыг тохирсны үндсэн дээр 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортлож эхэлсэн. Монгол Улс 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортлосон ба Дэлхийн нийтийн хамарсан Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар 6.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортлосон байна.	30

31	3.3.15. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх	3.3.10.1."Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк(ҮТП)-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	"Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Италийн талтай хамтран цэвэрлэх байгууламжийн ерөнхий схемийг боловсруулан, шаардагдах тоног төхөөрөмжүүдийн тооцоо судалгааг гарган, ТЭЗҮ-д тусгасан. ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу "Цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Чанарын түншлэл" ХХК шалгаран, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ДАШЦБЕТӨХХК/202206019 дугаартай гэрээг Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-тай байгуулан ажлыг эхлүүлсэн. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд усан сангийн барилгын бүтэц, барилгын архитектурын ажлын зураг хийгдэж дууссан бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын гэрээний хугацааг гүйцэтгэгч компанийн хүсэлтийн дагуу сунгаад байна.	30
32	3.5.5. Чойр-Сайншанд чиглэлийн 230 км урттай, 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	3.5.5.1.Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина	Чойр-Сайншанд чиглэлийн 230 км урттай, 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	МУЗГ, ЕСБХБ хоорондын "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд 300 сая ам.долллын санхүүгийн эх үүсвэрээс 56,6 сая ам.доллаар Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг санхүүжүүлэхийг ЗГ-ын 2019.09.18-ны өдрийн 356 дугаар тогтоолоор баталсан. Төсөвт өртөгт дутагдаж байсан санхүүжилт болох 13,8 сая ам.долларын 8 сая ам.долларыг нь ЕСБХБ-аас, 5 сая ам.долларыг Европын холбооны буцалтгүй тусламжаар шийдвэрлэхээр уг төслийн зээлийн гэрээний хэлцэл 2022.08.26-ны өдөр амжилттай хийгдсэн. Төслийн ТЭЗҮ-ийг Mercados Aries International компани болон "Мон-Энержи консалт" ХХК, Байгаль орчин, нийгмийн судалгааны ажлыг Sustainability East Asia болон Atkins компаниуд, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Эко трейд" ХХК тус тус хийж гүйцэтгэж, тайлангууд баталгаажсан. Говьсүмбэр, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 220.04 км урттай ЦДАШ-ын трассын дагуух газрыг баталгаажуулан Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллийн санд бүртгүүлж, орон нутгаас газрын гэрчилгээнүүд албажсан. ЕСБХБ-наас төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд "Work shop" өдөрлөгийг 2022.06.09-ний өдөр зохион байгуулсан. Төслийн зээлийн гэрээний хэлцэл амжилттай хийгдэж, зээлийн гэрээнд ЕСБХБ, МУ-ын Сангийн яам гарын үсэг зурсан. "Төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг байгуулах тухай саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийн БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтуудыг банкны шаардлагын дагуу боловсруулах "Хувь зөвлөхүүд"-ийг төслийн техникийн тусалцааны хүрээнд авч ажиллуулах саналтай байгаагаас тус яамны зүгээс ЕСБХБ-д хүргүүлсэн.	30
33	3.5.8. 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих	3.5.1.6.160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина.	160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих	Төслийн гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна.	Зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулж, ХБНГУ-ын "RWE Technology International GmbH" компани болон МУ-ын "Мон-Энержи-Консалт" ХХК-ийн баг шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Байгаль орчны мониторинг хийх, жөндөрийн чиглэлээрх ажлуудыг хэрэгжүүлэх компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. ЭХХЗХС-ийн нэгдсэн сүлжээнд үзүүлэх туслах үйлчилгээний үнэ тариф, зах зээлийн дүрмийг эхний байдлаар боловсруулсан. Шинээр баригдах том чадлын цэнэг хураагуурын станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох Техникийн нөхцөлийг олгосон. 2021-2022 онд БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зохион байгуулсан. АХБ-наас үл татгалзах хариу ирүүлсэнээр 2022.06.09-ний өдөр Үнэлгээний хороо төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмжийг өгсөн. Дэлхийн зах зээл дээрх цэнэг хураагуурын түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан тендер ирүүлсэн компаниуд үнээ нэмэх нөхцөл тавьж, АХБ-ны зөвлөмжөөр эхний тендер хүчингүй болж, дахин зарлагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын ZTT-ZEST консорциум шалгарч, 2022 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан ба АХБ-ны зөвлөмжийн дагуу гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Барилга угсралтын ажлыг 2022.08.04-ний өдөр эхлүүлсэн ба төслийн ажлын зураг хийгдэж байна. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл эхэлсэн. Ерөнхий зураг төслийн ажлын хүрээнд ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК, Төслийн менежментийн зөвлөх компани (ТМЗК) зэрэг талуудын хамтарсан хурлыг 2022.10.26-ны өдөр зохион байгуулж шийдлүүд дээр саналуудаа нэгтгэв. Төслийн хүрээнд "Эрчим хүчний салбарт ажиллаж буй 120 эмэгтэй инженерүүдийг чадавжуулах сургалт"-ыг 2022.10.24-28-нд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 20.0 хувьтай байна.	25

34	3.5.10. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг эхлүүлэх	3.5.4.4. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг эхлүүлэх	Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 20,45 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл" -ийн хүрээнд 220, 110 кВ-ын дэд станцуудад ашиглагдаж буй ашиглалтын хугацаа дууссан, насжилт болон элэгдэл ихтэй 110 кВ-ын тосон болон хуурай таслуурыг гүйдлийн трансформатор, реле хамгаалалт удирдлагын хамтын шинэчлэх, төвийн бүсийн эрчим хүчний системийн гол зангилаа 220 кВ-ын 4 дэд станцын реле хамгаалалт, автоматик, хяналт, удирдлагын системийг бүрэн шинэчилж, өргөтгөх ажил хийгдэнэ. Төслийн зөвлөхөөр шалгарсан Герман Улсын Integration Umwelt & Energie компанитай гэрээ байгуулсан. Олон улсын төслийн удирдагч нар Монгол Улсад ирж төсөл хэрэгжих 24 дэд станцад газар дээр нь ажиллаж төслийн ажлын эзлэхүүнийг тодорхойлон шаардлагатай өгөгдөл мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэсэн. Ажлын эзлэхүүнд нэмэлтээр 35 кВ-ын 45 ширхэг тосон таслуур, 135 ширхэг гүйдлийн трансформатор, 25 ширхэг РХА-ыг шинэчлэх, мөн 220 кВ-ын 4 дэд станцын 220,110 кВ-ын хүчдлийн трансформатор шинэчлэх ажлыг нэмж оруулахаар Зөвлөх компанитай хамтран төслийн нэгдсэн ажлын эзлэхүүн, анхдагч болон хоёрдогч хэлхээний тоноглолуудын техникийн тодорхойлолт, схем зургийг бэлтгэн түлхүүр гардуулах нөхцөл бүхий төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийн баримт бичгийг боловсруулж 2022.11.04-ний өдөр төслийн санхүүжүүлэгч Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-д хүргүүлж "Үл татгалзах зөвшөөрөл" авах хүсэлт гаргасан. KfW банк тендерийн баримт бичгийг хянаж, шалгах ажил хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 10 хуьтай байна.	20
35	3.5.11. Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	3.5.5.4. Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина	Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	Төслийн гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна.	Тайширын УЦС-аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 2019 онд эхлүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан боловч тендэрт оролцогчдоос маргаан үүсэж шүүхэд шилжсэн ба шүүхийн маргаан оны 4 дүгээр улиралд эцэслэгдсэнээр Худалдан авах ажиллагааны газраас дахин нээлттэй тендерийг 2020.12.12-нд зарласан. Эрчим хүчний сайдын 2021.02.10-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсэг Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тендэрт шалгарсан "Биндэнгоров" ХХК-тай гэрээний хэлцэл хийж, 2021.02.10-ны өдрийн ЭХА-001/2021 дугаартай гэрээг байгуулсан. Төслийн барилга угсралтын 2021.03.11-ний өдрийн 2021/Ц-34 тоот Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгож, ажлыг эхлүүлсэн боловч Захирааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол ирсэнтэй холбоотойгоор ажил түр зогсож, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тул хэргийг хэрэгсэхгүй болгож захирамж гарсан. Цар тахалтай холбоотойгоор тулгуурын захиалга болон нийлүүлэлт оройтсон мөн ажлын зурагт өөрчлөлт орох болсон зэрэг шалтгааны улмаас тус төслийн ажил удааширсан бөгөөд төслийн БУА-ыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлсэн. Төслийн хүрээнд баригдах 110/35/6 кВ-ын 10 МВт-ын хүчин чадалтай дэд станцын газрыг өөрчилж дахин геодезийн дүгнэлт хийлгэж, шинээр газар сонгон талбайг тэгшилж дэд станцын барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. Шугамын болон бусад тоног төхөөрөмжүүдийг 100 хувь захиалсан, дэд станцын газар шорооны ажлууд хийгдсэн. Станцын газардуулга болон хашаа барьсан. Дэд станцын тоноглолын суурь УСО босгож дуусгасан. 110кВ-ын ЦДАШ-ын тулгуур гагнах, тулгуурын ажил хийгдэж байна. Төслийн хэрэгжилт 20 хувьтай байна.	20
36	3.5.13. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	3.5.5.2. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина	Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Тус төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил хийгдэж баталгаажсан. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ болон ЕСБХБ-тай хамтран ажилласан ба ЗГ-ын 2022.02.30-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлээр АХБ-ны санхүүжилтээр дэмжигдсэн. ЦДАШ-ын 468.3 км урт трассыг баталгаажуулах асуудлаар Ховд, Завхан аймгуудын ИТХ-ын дарга болон Засаг дарга нартай хамтран ажиллаж орон нутгийн газрын албаны мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших гэрээг баталгаажуулсан. АХБ-аас уг төсөл нь санхүүжих төслийн шаардлагыг хангасан талаар болон мөн шувууны нүүдлийн судалгааны дүгнэлт гарсан талаар тус тус мэдэгдсэн. Төслийн зээлийн гэрээг СЯ-наас 2022.06.27, 28-ны өдрийн УИХ-ын байнгын хороодын хуралд танилцуулж дэмжигдсэн. СЯ-наас 2022.07.07-ны өдрийн 03/4858 тоотгоор төслийн санхүүжилтийг АХБ-аас 2022-2023 онд авч ашиглах 655 сая ам.доллар хүртэлх санхүүжилтийн эх үүсвэрээс 140.0 сая ам.доллартай тэнцэх санхүүжилтийг төсөлд хуваарилахаар төлөвлөсөн талаар мэдэгдсэн ба зээлийн ерөнхий хэлэлцээрт 2022.8.26-ны өдөр АХБ болон СЯ гарын үсэг зурсан. Төслийн БОННУ-ний судалгааг хийж байгаа АХБ-ны Зөвлөхүүд 2022 оны 06 дугаар сараас эхлэн 3 сарын турш Ховд, Завхан аймгуудын нутагт Эрдэнэбүрэн УЦС-ыг барих талбай болон ЦДАШ-ын трасс дагуу ажиллаж, орон нутгийн иргэд, тусгай хамгаалалттай газрын захиргаа, орон нутгийн удирдлагуудтай уулзаж ажилласан. БОННУ-ний урьдчилсан тайланг 2022.09.21-ний өдөр танилцуулсан бөгөөд төслийн трасс дагуу нүүлгэн шилжүүлэх болон нөлөөлөлд өртөж байгаа айл өрх, өвөлжөө, хаваржаа байхгүй мөн шувуудын нүүдлийн замаас хол учир Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө бага, хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарсан талаар мэдэгдээд байна. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг 2022.09.15-ны өдрийн а/3490 тоотгоор СЯ-нд хүргүүлсэн. АХБ-ны зүгээс төслийн зээлийн гэрээг 2023 оны 09 дүгээр сард батлуулах төлөвлөгөөтэй байна. Төслийн ХАА-ны төлөвлөгөөг боловсруулж байна.	30

37	3.6.4. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг чадавхжуулах хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх	3.6.1.3.3.Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг чадавхжуулах хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх	Гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааг чадавхжуулах замаар Монгол улсын төмөр замын чадварыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд: - Нийслэлийн Засаг даргын 2022.01.11-ний өдрийн А/15 тоот шийдвэрээр Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нэгж талбарын 1681610100 дугаар бүхий 4000 м.кв Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ авсан. - 2022.03.04-ний өдөр МЗХ2022/02-005 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар авсан. - ЗТХЯ, Төслийн менежментийн зөвлөх (РМС) багтай хамтран 2022.06.22-07.01-ний өдөр Сайшанд, Зүүнбаян, Хулангын Шанд, Сүхбаатар, Төмөртэй, Хандгайт өртөө, "УБТЗ"-ын дохиолол холбооны II анги, УБ II өртөөнд ажиллаж RFID (радио давтамжаар тодорхойлох), CCTV (камер) систем суурилуулах байршлын судалгаа хийсэн. - 2022.08.12-нд Төрийн худалдан авах ажиллагааны газар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер заралсан. - Төслөөр хэрэгжих системийн програм болон техник хангамжийн тасралтгүй ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх зорилгоор 8 байгууллагын 20 ажилтныг хамруулсан сургалтыг Солонгосын төмөр замын корпораци (Korail)-тай хамтран 2022.09.21-30-ны өдөр зохион байгуулж, төслийн менежментийн зөвлөх (РМС) багаас явцын тайлан тавьж, хяналтын болон дамжуулах сүлжээний системийг танилцуулсан. - Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022.08.30-ны өдөр ГТХЗНТ-ийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ГТХЗНТ/202208001 дугаартай тендер зарлаж тус газрын 2022.10.18-ны өдрийн А-1/2331 тоот албан бичгээр барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх сонгон шалгаруулалтад "хамгийн сайн" үнэлэгдсэн тендэрт оролцогчоор шалгарсан "Эм Эс Эл" ХХК-тай тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан гэрээ байгуулах зөвлөмжийг ирүүлсэн. Төвөөс зөвлөх үйлчилгээний гэрээний төслийг боловсруулж 2022.10.28-ны өдөр ЗТХЯ, "Эм Эс Эл" ХХК, Койкагийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар хамтран гэрээ байгуулсан.	30
38	3.6.9. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх	3.6.1.8.9.Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ.	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	Улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.	0
39	3.6.14. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах	3.6.3.1.2.Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.	Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах	Цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц байгуулсан байна.	Энэхүү арга хэмжээг ЗТХС, 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан. Улсын хэмжээнд 20-60 квт-ын хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, автотээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх станц 21 аймагт 80, Улаанбаатар хотод 54-г үйлчилгээнд ашиглаж байна. Нийслэлийн 8 байршилд шинээр өндөр хүчин чадалтай цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 25 станц барих санхүүжилтийг 2023 оны Агаар, орчны бохирдлыг бууруулах сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	30

40	3.6.23. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих	3.6.1.6.3.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой- Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барина	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	2019 онд концессын гэрээ хүчин төгөлдөр болсон ч орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүйгээс зам барилгын ажил гацаанд ороод байсан бөгөөд Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Засаг даргын 2022.01.26-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/05 дугаар захирамж гарснаар гүйцэтгэгч компани зам барилгын ажлыг эхлүүлэхээр нүүлгэн шилжүүлэлтийн ажил эхэлсэн боловч нутгийн иргэд, малчдын эсэргүүцэлтэй тулгаран, тодорхойгүй нөхцөл байдал үүссэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэг болон ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 3, 4 сард газар дээр нь ажиллаж, ард иргэдтэй уулзалт хийсэн. Үүний дараа Ерөнхий сайд 2022.05.26-27-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажиллаж, ард иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсооны үндсэн дээр Цагаандэл-Уул боомт нэхэээр шийдвэрлэсэн Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Цагаандэл Уул боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, ЗТХ-ын сайд Л.Халтар нарт даалгасан. Түүнчлэн Ерөнхий сайд 2022.07.20-ны өдөр 107 дугаар захирамж гарган, Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Мөн ЭЗХЯ дээр уг ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүйгээс зам барилгын ажил зогссон.	0
41	3.6.24. Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх	3.6.1.7.2.Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина	Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 20.8 тэрбум төгрөг төлөвлөснийг 2.5 тэрбум төгрөг болгон баталсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар сонгон шалгаруулалтыг 3 удаа зарласан. Сүүлийн төндөрийн нээлт 2022.09.13-нд нээсэн нэг ч оролцогч оролцсоогүй байна. Тус ажлын төсөвт өртгийг дахин магадлалаар оруулж, 2023 оны улсын төсөвт санхүүжилтийг суулгасан. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдсан.	0
42	3.6.25. Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих	3.6.1.7 Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Чойбалсан-Хавиргын хилийн боомтын чиглэлийн 124.5 км, Норовлин-Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж эхлүүлнэ.	Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна.	Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3 км /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/ төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2022.04.28-ны өдөр Монгол зам групп ХХК, Голд өлзийт ХХК-ийн түншлэлтэй гэрээ байгуулсан. Харин Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж 2022.05.23-ний өдөр Түм-Арвижих ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон. Гэвч Түм-Арвижих ХХК нь шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг төндөрийн хүчинтэй хугацаанд багтаан ирүүлээгүй тул хүчингүй болсон. Иймд 2022.06.08-ны өдөр дахин зарласан ба нээхэд 2 оролцогч оролцсон бөгөөд үнэлэхэд шаардлагад нийцээгүй тул дахин 2022.07.20-ны өдөр зарласан. Төндөрийг нээхэд мөн адил 2 оролцогч оролцсон ба үнэлэхэд шаардлагад нийцээгүй. Үнэлгээний хорооны шийдвэрт гомдол гарсан бөгөөд Сангийн яамнаас дахин үнэлэх шийдвэр ирүүлсэн ба Үнэлгээг хийж байна. 2022 оны Улсын төсөвт 9.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 2.5 тэрбум төгрөг тусгагдсан. 2022 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 6 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, төндөр амжилтгүй болсон. 2023 онд дахин төндөр зарлана. Төсвийг 2023 оны улсын төсөвт нэмэгдүүлж батлуулсан.	0
43	3.6.29. Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх	3.6.1.8.13.Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замыг барина	Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Авто замын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	Төрийн худалдан авах ажиллагааны газраас уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулахаар тус яамнаас ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрийг авсан. ЗГХЭГ-аас концесс, төрийн хувийн хэвшлийн чиг үүргийг ЭЗХЯ хариуцах болсонтой холбогдуулан ТХААГ-т буй төслүүдийн мэдээллийг хүлээлцэх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан ажлын хэсэг байгуулах ажил түр хойшлогдсон байна. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар хуваарь гарган Засгийн газрын хуралдаанд танилцуулах шийдвэрийн дагуу 2022.03.30-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто зам төсөл"-ийн зардал, үр ашгийн тооцоог 2 хувилбараар боловсруулж, товч танилцуулга, мэдээллийн хамт 2022.05.11-ний 03/2161 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Засгийн газрын 2022.05.04-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор БУ-Бичигт чиглэлийн замын концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг ТХААГ-т даалгасан. ТХААГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу 2020.06.22-ны өдөр концесс олгох ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрсийг хүргүүлсэн бөгөөд ажлын хэсэг байгуулагдсан боловч тус газраас өнөөдрийг хүртэл ажлын хэсгийн хуралдааныг зарлах ажлыг зохион байгуулаагүй, хүлээгдэж байна.	0
44	3.6.30. Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	3.6.1.6.2.Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Овоотын уурхайгаас Арцсуурь хилийн боомт хүртэлх авто замын ТЭЗУ, зураг төсөл боловсруулна	Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулж, трасс батлагдсан байна.	Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор тус чиглэлийн төмөр замыг зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэхээр концессын зүйлийн жагсаалтад оруулсан. Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замыг төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн" ХХК байгуулан Концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг "Монголын төмөр зам" ТӨХК-д даалгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Монголын төмөр зам" ТӨХК-аас Төслийн тусгай зориулалтын компанид хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулалт хийсэн. Оролцогч байгууллагаас шүүхэд гомдол гаргасан тул хүлээгдэж байна.	30

45	3.6.31. Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих	3.6.1.8.17.Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барина /Ховд, Увс аймаг/	Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байна.	2022 оны улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус яамтай хамтран хэрэгжүүлж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн 3 дугаар шатны хүрээнд Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих хөрөнгийн асуудлын хүрээнд АХБ-ны зүгээс төслийн өмнөх урьдчилсан судалгааг (РРТА) эхлүүлсэн. Зөвлөхөөр ХБНГУ-ын "Kocks consult GmbH" компани шалгарч судалгааны ажлыг эхлүүлсэн. Ажлын явцын талаар АХБ, ЗТХЯ, Зөвлөх компани хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2022.09.13-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Харилцан ойлголцлын санааж бичиг байгуулсан. Зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан. Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэж дэмжигдсэн.	30
46	3.6.32. Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	3.6.4.2.1.Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.	Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	Аэродромтой болгон нислэгийн дэд бүтэц өргөжиж, орлого өснө. Зүүн бүсийн ачаа тээврийн логистик төв болгон экспортыг нэмэгдүүлнэ.	Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Чойбалсан нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж байна. Мөн "Жайка" ОУХАБ-аас хэрэгжүүлж буй "Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын болгож, ашиглалтыг сайжруулах төслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд хүргүүлсэн (2022.10.04-ний 01/4549). Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30
47	3.6.33. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	3.6.4.2.2.Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.	Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	Зорчигч үйлчилгээний шинэ цогцолбор, нислэг хөдөлгөөний цамахаг бүхий нийт 9000 м2 барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Хөөрч буух хучилттай зурвасыг 2850x45 метр хэмжээтэй болгон өргөтгөж хүчитгэл хийнэ.	Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.03.02, 2022.05.25-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Ховд нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-ээр 2022.03.14-ний өдөр олон улсын нисэх буудал гэж зарласан. Ховд нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30
48	3.6.34. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	3.6.4.2.3.Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.	Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	Хөөрч буух хучилттай зурвасыг 2850x45 метр хэмжээтэй болгон өргөтгөж хүчитгэл хийнэ.	Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. Концессын зүйлийн жагсаалтад тусгах бэлтгэл ажлыг хангах хүрээнд төслийн зардал, үр ашгийн тооцоог хийсэн. Мөн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөрөн нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-ээр 2022.04.07-ны өдөр олон улсын нисэх буудал хэмээн зарласан. Мөрөн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар ИНЕГ-т 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30

49		3.6.35. Сайншанд-Баруун-Урт-Хөет-Бичигт, Хөет-Чойбалсан чиглэлийн 667 км төмөр замын төслийг эхлүүлэх	3.6.1.1.3.Дорноговь аймгийн Сайншанд - Баруун-Урт - Хөет чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ 3.6.1.1.5.Дорнод аймгийн Хөет-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийг эхлүүлнэ	Сайншанд-Баруун-Урт-Хөет-Бичигт, Хөет-Чойбалсан чиглэлийн 667 км төмөр замын төслийг эхлүүлэх	Төмөр замын зураг төслийг хийж, төслийг эхлүүлсэн байна.	Сайншанд-Баруун-Урт-Хөет чиглэлийн төмөр замын төслийг Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтад шууд гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэхээр нэмэлтээр оруулсан. Концессын шийд гэрээ байгуулах сонгон шалгаруулалтыг зарлуулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээд байна. БНСУ-ын хөгжлийн албан ёсны туслалцааны хүрээнд нэг хэсэг болох тус чиглэлийн төмөр замын техник-эдийн засгийн судалгаа хийхээр Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгосын Газар, дэд бүтэц, тээврийн яамтай Санамж бичиг байгуулсан. Сайншанд-Баруун-Урт-Хөет чиглэлийн төмөр замын техник-эдийн засгийн судалгааны ажил эхлүүлсэн. - Чойбалсан-Хөет-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулсан ба Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөет-Бичигт чиглэлийн төмөр замын	30
50	3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	3.7.1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	3.7.13.2.Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.	Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	Зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	"Эрдэс плазма" ХХК-ийн Багахангай дүүрэгт байгуулах шилний үйлдвэрийн төсөлд дэмжлэг үзүүлж, Засгийн газрын 2021.08.04-ний өдөр 227 дугаар тогтоолоор УТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. Үйлдвэрийн зураг төслийг урьдчилан байдлаар 220 мянган ам.доллараар боловсруулсан. Тус яамнаас Хөгжлийн банканд хандан, шилний үйлдвэр байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн. Хөгжлийн банк энэ асуудлыг судалж үзээд, төслийн судалгаа зогсоосон тул Дэлхийн банкны олон улсын санхүүгийн корпорацид хүсэлт гарган төслөө судлуулж байна. ОУСК-аас түүхий эдийн ордуудыг ашиглаж эхлэх шаардлага тавьсан тул үндсэн түүхий эдийн нэг болох Дундговийн Өлзийтийн кварцын ордод хийсэн хайгуулын ажлыг 2021.12.01-ний өдөр УУХУЯ-ны Эрдэс байглийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, нөөцийн тайланг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Налайхын Элстэйн цахиурын элсний ордон ТЭЗҮ-ийг 2022.3.22-ны өдөр дээрхи Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны БОУ-ний комиссын хурлаар 2022.6.07-нд хэлэлцүүлэн батлуулсан. Энэ ордыг ашиглахад шаардагдах цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл олгох тухай хүсэлтийг "Улаанбаатар цахилгаан түүгээх сүлжээ" ТӨХК-д 2022.6.15-ны өдрийн 3/2885 тоотор хүргүүлсэн. Дорноговийн Сайхандулааны кварцын ордон нөөцийн тайланг 2022 онд хэлэлцүүлэхээр УУХУЯ-амаан дээр хүлээгдэж байна. төслийг дэмжсэн хүсэлтийг дахин Хөгжлийн банканд 2022.10.06-ны өдрийн 3/4622 тоотор хүргүүлсэн. Шилний үйлдвэр нь стратегийн ач холбогдол бүхий хүнд үйлдвэр тул хамтран ажиллах тухай саналыг УУХУ-ийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4717 тоотор, Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4720 тоотор хүргүүлж, дэмжлэг хүсч, хамтран ажиллаж байна. Шилний үйлдвэрийн зураг төслийг урьдчилсан байдлаар 220 мянган ам.доллараар боловсруулж, батлуулсан.	0
4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
51		4.1.4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох	4.1.1.10.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох		Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын хамтарсан 2022 оны А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан "Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2022.10.12-ны өдөр ЭХЭУБГ-ын дарга болон МТГ-ын программ хангамжийн хэлтсийн дарга нар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт очин хаягийн мэдээллийн нэгдсэн системтэй биечлэн танилцаж, систем хөгжүүлэгч болон ГЗБГЗЗГ-ын холбогдох удирдлагуудтай уулзалт зохион байгуулж цаашид хийгдэх ажлын талаар санал солилцсон. Мөн "Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" үүсгэхтэй холбоотой ажлын танилцуулга, гарч болзошгүй зардлын тооцоог бэлтгэж ажлын хэсэгт хүргүүлсэн. ГЗБГЗЗГ-ын зүгээс 10 дугаар сарын 19-ний өдөр Хаягийн мэдээллийн нэгдсэн сангаа УБЕГ-т илгээсэн, тус мэдээллийн санг ЭХЭУБГ-ийн мэдээллийн сантай тулгалт хийх ажлыг МТГ хариуцан ажиллаж байна. Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" –г хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яамны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд нарын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэгт Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга нар оролцон ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлэн ажиллаж байна.	0
52		4.1.9. Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох	4.1.6.3.Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно.	Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах аргачлалыг боловсруулж боловсон хүчнийг бэлтгэх лаборатори бэлэн болсон байна	Мэдээллийн аюулгүй байдлын сургалтын тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Японы улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Техникийн хамтын ажиллагааны төслөөр их дээд сургуулиуд, Удирдлагын академ, И-Монгол академ Улсын төсөвт үйлдвэрийн газрын мэдээллийн аюулгүй байдлын сургагч багш нарыг чадваржуулахаар тохиролцож, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Сургагч багш бэлтгэх сургалтыг 2023 оны эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд Шинжлэх ухаан технологийнх сургуульд түшиглэн сургагч багш бэлтгэх сургалтын лабораторийг байгуулахаар ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нарын 2022 оны А/260, А/391, А/146, А/260 дугаар хамтарсан тушаалаар "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)"-г баталсан. Уг төлөвлөгөөнд "Ахисан түвшний сургалт"-ын хөтөлбөрт кибер аюулгүй байдлын талаар багц сургалтын хөтөлбөр бэлтгэхээр тусгасан.	30

53	4.1.10. Нэгдүгээр ээлжийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төв /үндэсний CERT/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх	4.1.6.1. Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна. 4.1.6.5. Үндэсний CERT-ийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	Нэгдүгээр ээлжийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төв /үндэсний CERT/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх	Бусад төв болон онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагуудыг холбосон нэгдсэн төв байгуулагдсан байна.	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв /Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан нэршил/ байгуулах Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгааг хийж, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр баталсан "Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай" албан даалгаварт кибер халдлага зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэхээр үүрэг болгосны дагуу иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах нийтийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах санал боловсруулж, Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 01/1307 дугаар албан бичгээр яамдад хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дэмжих боломжгүй гэж үзсэн. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах асуудлаар 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулсан. Америкийн Нэгдсэн Улсын Карнеги Меллоны Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд Кибер аюулгүй байдлын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэхээр "Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг байгуулах" сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 20 байгууллагын 34 албан хаагч хамрагдсан. Санхүүжилтгүйн улмаас тоног төхөөрөмжийн худалдан авалт удаашралтай байна.	30
54	4.1.15. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах	4.1.5.5. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.	Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах	Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлсэн байна.	Барилгын хөгжлийн төвийн захиалгаар "Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зураг төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм"-ийг шинээр боловсруулах ажлыг "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК болон "Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци"-ийн хамтарсан баг гүйцэтгэн Барилгын хөгжлийн төвийн дэргэдэх Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар танилцуулан, гишүүдийн саналаар дэмжигдсэн боловч Барилга хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна. Мөн Газрын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1319 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн төслийг байнгын хороодоор хэлэлцүүлэх ажлыг Барилга, хот байгуулалтын яамаас зохион байгуулж байна. Дээрх хуулиудад өөрчлөлт орсноор харилцаа холбооны дэд бүтцийн бүтээн байгуулалт нь бусад инженерийн дэд бүтэцтэй уялдах юм. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ний А/76 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд Тоон радиогийн ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулсан. Мөн 2023 оны улсын төсвийн төсөөлөлд тусуулахаар санал хүргүүлсэн.	30
55	4.1.16. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах	4.1.5.7. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна	Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах	617 км физик кабелийг чөлөөлж, 75.2 км шилэн кабель татсан байна.	Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн худаг сувагчлалын зураглалын дагуу чөлөөлөх шаардлагатай зэс кабель, шинээр татах шилэн кабелийн тооцоог гаргаж, санал боловсруулан 2023 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн хязгаарын саналд суулгуулан Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ ажилд "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Монголын цахилгаан холбоо" Хувьцаат компани хамтран оролцож байгаа бөгөөд одоогоор "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ажил эхэлж хотын төв зам дагуу Наран станцаас зүүн тийш Офицеруудын ордон чиглэлд, КШ-32 оор Бага тойруугаас их тойруу чиглэлд, КШ-68 аар, КШ-45 чиглэлд нийт 54,769 м кабель чөлөөлөх ажил явагдаж байна.	30
56	4.2.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах	4.2.6.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулна.	Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах	Сургалт судалгаа, зөвлөх үйлчилгээний чанарын индекс нэмэгдсэн байна.	Удирдлагын академийн сонсогчдын дотуур байр, дэмжих үйлчилгээний төвийн шинэ барилга баригдаж эхэлсэн бөгөөд 2021 онд 500 сая, 2022 онд 2.4 тэрбум төгрөг батлагдсан. Тус барилга нь сургалт, мэдээллийн төвийн байр, сонсогчийн дотуур байр, спорт заал бүхий 3 корпустай байхаар зураг, төсөв хийгдсэн ба нийт талбайн хэмжээ 11,621.1 м.кв, төсөвт өртөг нь 18,827.2 сая төгрөг юм.	30

57	4.3.9. Хилийн 4 боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх	4.3.1.5.Хилийн боомтуудыг "Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем"-ээр төхөөрөмжилж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, шалгалтын техник, хэрэгслээр хангах, цэргийн холбооны техник хэрэгсэл, хүн нэг бүрийн тусгай хэрэгслийг шинэчлэнэ.	Хилийн 4 боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх	Шинээр нэгдсэн системд холбох боомтын тоо - 4.	Хилийн "Гашуунсухайт", "Ханги", "Хавирга", "Замын-Үүд" боомтуудыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх тооцоо судалгааг 2023 оны төсвийн төсөөлөлд тусгуулах саналыг ирүүлсэн. -Хилийн "Замын-Үүд" боомтод шилэн кабелийн дохиолол хяналтын системээр төхөөрөмжлөх шийдэл боловсруулах зорилгоор "Мобинет" ОХУ-ын "Оргэнергострой" ХХК-уудтай хамтран ажилласан.	30
58	4.3.12. Нийслэл, 21 аймгийн онцгой байдлын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийг байгуулж, нэгдсэн системд холбох; "Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төсөл хэрэгжүүлж эхлэх	4.3.11.1."Монгол Улсад зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоо, гамшгийн бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл" хэрэгжүүлнэ	Нийслэл, 21 аймгийн онцгой байдлын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийг байгуулж, нэгдсэн системд холбох; "Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төсөл хэрэгжүүлж эхлэх	Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийг удирдах хороо байгуулагдсан байна. Зээлийн төслийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан байна. Төслийн хүрээнд нийлүүлэгдэх техник, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг эхлүүлсэн байна. Шаардлагатай сургалтууд зохион байгуулагдсан байна.	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэл нэгдсэн системийг улсын хэмжээнд байгуулах, гамшгаас хамгаалах, бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж, гамшгийн улмаас учрах хохиролыг бууруулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2020-2022 онд "Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" техникийн тусалцааны төслийг хэрэгжүүлж, Азийн хөгжлийн банкны 33 сая доллар /30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3 сая ам.долларын буцалтгүй тусламж-ын санхүүжилтээр хэрэгжих "Монгол Улсад гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан. Тус төслийг 2023 онд хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Шадар сайдаар уламжуулахаар 2022.11.25-ны өдрийн 1/2479 дугаар бичгээр Монгол Улсын Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүсэлт хүргүүлсэн.	30
59	4.3.15. Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх	4.3.13.1.Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.	Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх	9 боомт, 17 терминалыг түргэвчилсэн шинжилгээний багаж хэрэгслээр хангасан байна.	Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангах төсөв батлагдаагүй болно.	0
60	4.3.18. Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлэх	4.3.11.2.Цаг агаарын гэнэтгийн аюулт үзэгдлээс амжих анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бусад аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.	Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлэх	Автомат станц, хэмжих хэрэгсэл 50 ширхийг худалдан авч цаг уурын өртөөг 100 хувь, харуулын 30 хувийг хангасан байна.	Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал 2022 оны Монгол улсын төсөвт тусгагдаагүй тул тус газраас хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд Бүгд найрамдах Солонгос улсын Цаг уурын байгууллагад цаг уурын автомат станц суурилуулах төсөл хэрэгжүүлэх санал тавьсаны дагуу БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2023 онд 20 ш автомат станц Өвөрхангай, Дундговь аймгуудад суурилуулах төсөл хэрэгжүүлэх болсныг албан бичгээр мэдэгдсэн. Энэ ажлын хүрээнд 2022 оны 8 болон 11-р сард Солонгосын цаг уурын байгууллагын мэргэжилтнүүд Монгол улсад ирж төслийн урьдчилсан судалгаа хийсэн бөгөөд төсөл хэрэгжихэд бэлэн болсон.	30
5.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГ						
61	5.1.8. Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх	5.1.12.5.Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Дюпелерын Радарын станц байгуулна.	Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх	Хэнтий аймагт радарын станц байгуулсан байна.	Монгол Улсын 2022 оны төсөвт холбогдох зардал тусгагдаж батлагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй байна.	0
6. НИИСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГ						
62	6.1.9. Улаанбаатар хотын	6.1.6.1.Нийслэлийн авто	Улаанбаатар хотын	Хотын шинэ тойрог зам 71.5 км	Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин	30

